



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 99031809 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Т.ХАТАНБААТАР ТАНАА

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.22 № 263

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Алтай сум нь тайлант 3,314 хүн амтай, жилийн эцсийн мал тооллогоор 212,453 толгой мал тоолуулжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Алтай сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 843.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 159.7 мянган төгрөг буюу 23.3 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Тайлант онд 3,962.5 сая төгрөгийн зардал батлагдаж гүйцэтгэлээр 2,873.8 мянган төгрөгийг зарцуулснаас 1,772.3 сая төгрөгийг урсгал зардалд, 946.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 65.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулжээ.

Бусад асуудлын хэсэг

2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 бодлогын 32 зорилтын хүрээнд 192 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, дэвшүүлсэн зорилт гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга 82.2 хувиар үнэлсэн байна.

8436050842

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,553,091.8	1,998,694.81
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	681,969.6	1,118,811.1
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	190,510.71	261,404.37
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	475,490.74	406,074.64
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	205,120.75	212,404.71
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,229,249.33	6,899,245.17
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	5,229,249.33	6,899,245.17
8	1.2.2.02 Биет хөрөнгө		5,225,249.33	6,895,245.17
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	4,000	4,000
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		6,782,341.12	8,897,939.98
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		78,054.59	101,963.97
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		78,054.59	101,963.97
13	2.1.1.03 Өглөг		78,054.59	101,963.97
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,704,286.53	8,795,976.01
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		6,704,286.53	8,795,976.01
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		1,034,383.68	1,034,383.68
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		5,091,480.47	7,183,169.95
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		578,422.38	578,422.38
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		6,782,341.12	8,897,939.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		5,367,284.73	5,487,258.31
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		779,910.89	800,340.2
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		670,065.84	623,591.63
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		688,180.62	673,699.08
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-18,114.77	-50,107.45
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		41,014.06	47,370.72
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		68,830.99	129,377.85
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,503,479.03	4,686,918.11
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	1,234,182.61
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,083,894.82	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,105,072.69	3,388,345.85
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		4,105,072.69	3,388,345.85
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,048,528.69	3,317,561.62
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		771,875.81	905,103.86
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		96,355.08	113,674.85
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		656,918.41	678,803.02
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		1,724,686.92	1,033,911.56
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		39,446.2	10,905.6
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		20,985.2	14,344.6

20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		53,340.75	43,448.42
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		684,920.33	517,369.71
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		56,544	70,784.23
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,262,212.04	2,098,912.46
24	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		1,262,212.04	2,098,912.46

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,442,074.49	5,442,074.49
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,442,074.49	5,442,074.49
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	1,262,212.04	1,262,212.04
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,704,286.53	6,704,286.53
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,704,286.53	6,704,286.53
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,222.98	-7,222.98
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,697,063.55	6,697,063.55
8	1.7 Тайлант үеийн үр дүн	2,098,912.46	2,098,912.46
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,795,976.01	8,795,976.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,031,694.05	3,620,189.09
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	779,910.89	800,340.2
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	670,065.84	623,591.63
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-18,114.77	-50,107.45
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	41,014.06	47,370.72
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	68,830.99	129,377.85
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,119.63	27,556.84
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	2,526.84	5,141.75
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	47,184.52	96,679.27
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,427.24	2,819,848.89
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	115,427.24	318,518.08
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,359,506.41
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1,141,824.4
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,136,355.92	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,259,464.28	2,171,859.46
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,259,464.28	2,171,859.46
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,200,938.78	2,100,914.73
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	765,059.09	938,022.89
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,299.8	112,018.39
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	655,989.91	662,694.47
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	165,995.54	38,073.01
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	553.7	0.0
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	99,305.9	16,117.2
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	20,985.2	14,344.6
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	137,104.8	58,953.43
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	258,644.84	260,690.74
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,525.5	70,944.73

28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,772,229.77	1,448,329.63
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,628,502.27	946,488.13
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,628,502.27	946,488.13
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	1,628,502.27	946,488.13
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,628,502.27	-946,488.13
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	65,000
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-65,000
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	143,727.5	436,841.5
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	538,242.1	681,969.6
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	681,969.6	1,118,811.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,473,371.3	3,434,626.9
11	3.1.01.1.1 Татварын орлого	665,321.1	800,340.2
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	551,750.0	623,591.6
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	601,857.5	673,699.1
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(50,107.5)	(50,107.5)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	46,850.0	47,370.7
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	66,721.1	129,377.9
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	15,550.0	27,556.8
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	3,511.1	5,141.7
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	47,660.0	96,679.3
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	2,808,050.2	2,634,286.7
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	458,737.0	284,973.5
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,207,488.8	1,207,488.8
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,141,824.4	1,141,824.4
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,962,467.3	2,941,374.4
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,009,162.2	1,929,886.3
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,003,282.8	1,858,941.5
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	954,407.6	910,386.1
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,301.2	112,018.4
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	712,258.4	662,694.5
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	40,195.1	30,355.3
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.2	-
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	18,614.7	16,117.2
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	17,307.0	14,344.6
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,429.9	48,210.8
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	67,085.7	64,814.6
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,879.4	70,944.8
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,738,718.7	946,488.1
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	214,586.4	65,000.0
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	489,096.0	493,252.5
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	556,645.8

5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,049,898.3
---	---	---	-------------

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	2024.12.31	2025.12.31
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	644,265.30	152,017.60
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	644,265.30	152,017.60
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	644,265.30	152,017.60
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	644,265.30	152,017.60
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	644,265.30	152,017.60
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	518,941.50	84623.5
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	518,941.50	84623.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	660.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82.50	
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	518,199.00	84623.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,000.00	
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	128,304.80	3328.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,871.90	
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,748.00	10742.6
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	203,274.30	70552.3
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	0.00	0
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	0
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	-	0
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	125,323.80	67394.1

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 394,608.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 52,500.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд:

- ОНХС-гийн авлагыг 52,500.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 342,108.3 мянган төгрөгийн алдаа илэрсний 321,798.0 мянган төгрөгийн алдаа нь материаллаг бус алдаа тул үлдэх 20,313.3 мянган төгрөгийн материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 86,607.9 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 342,108.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 342,108.3 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж бичлээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1 Зөвлөмж

3.1.1 Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-аар хөрөнгөөр хийгдсэн ажлуудад 2022-2023 онуудад 321,798.0 мянган төгрөгийн санхүүжилт олгоод авлагаар бүртгэсэн ч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, хяналтыг хэрэгжүүлээгүй 2025 онд тус ажлууд нь огт хэрэгжээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүргийг хүлээнэ”, 20,2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ОНХС-гийн авлагыг харилцагч байгууллага бүрээр гарган тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, гэрээний хугацаа дууссан аж ахуйн нэгжүүдээс олгосон санхүүжилтийг буцаан нэхэмжлэн авах.

3.1.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл арга хэмжээнд иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг баталж, биеийн тамир, спортын уралдаан тэмцээний зардалд 20,310.3 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахдаа иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлж, биеийн тамир, спортын уралдаан тэмцээнийг санхүүжүүлэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ОНХС	Авлагыг санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн	1	52,500.0	1	52,500.0			1	52,500.0				
ДҮН		1	52,500.0	1	52,500.0			1	52,500.0		0	0	0

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуульд	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ОНХС	Урьдчилгаа олгосон ч тайлант онд ажил хэрэгжүүлээгүй гэрээний хугацаа дууссан аж ахуйн нэгжүүдээс авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй	1	321,798.0					1	321,798.0		
Нийт дүн		1	321,798.0			0	0	2	321,798.0	0	0

4.3 Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

	Нийт зөрчил		Үүнээс
--	-------------	--	--------

Алтай сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитад хамрагдсан байгууллагын нэр			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ОНХС	1	20,310.3					1	20,310.3	-	-	-	-
Дүн	1	20,310.3	-	-	-	-	1	20,310.3	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			